

1-18 НАСНЫ МОНГОЛ СУРАГЧДЫН ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙГ Д.ВЕКСЛЕРИЙН АРГАЗҮЙГЭЭР СУДАЛСАН НЬ

О. Мягмар, профессор, Б.Туяа, дэд профессор,
Э.Октябрьжаргал, доктор, БоСС

Abstract: We conducted a research on the intelligence ability of Mongolian children aged between 11-18 in the scope of the project “The special feature of Mongolian children regarding mentality-physiology and society as well as culture” which supposed to be implemented by University of Pedagogic of Buryad, Russia and University of Pedagogic in Hoh, Inner Mongolia, China. To measure the ability of intelligence of senior and teenager or preadolescence kids, the WISC (Wechsler Intelligence Scale for Children), WAIS (Wechsler Adult Intelligence Scale, aged 16-64) developed by the American scholar D. Wechsler, was used by us as well. D. Wechsler’s idea was based on Intelligence is a complex ability of adaptation to the environment as well as a successful interaction to behavior with purpose, as a result to think rationally.

It was more characteristic for Mongolian children that they tend to be very intelligent in terms of education as well as cultural affairs, and were able to produce vocabulary using their native language, to release an induction based on their life experiences, observing ability and perceived attention, last but not least; evaluate things or to see the whole picture. But it should be considered further to develop their abilities in terms of improving to acquire a new skill more quickly, performing of real tasks as given and creative mind as well.

Түлхүүр үг: Оюун ухааны хөгжлийн түвшин, даалгаврын анализ, профиль

Удиртгал

Даяарчлалын өнөө үед улс орны эдийн засгийн хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйл нэг нь оюуны үйлдвэрлэл, өмчийн нэг чухал хэлбэр нь оюуны өмч болж буй нөхцөлд монгол хүний оюуны нөөц чадамжийг тодорхойлох, түүний түвшинг хэмжих, үнэлэх баталгаатай аргуудын хэрэгцээ зайлшгүй урган гарч ирж байна. Ийм аргуудыг эрж хайх ажил үндсэн хоёр замаар хэрэгждэг. Эхний зам нь гадаадын аргачлалуудыг орчуулж хэрэглэх, хоёр дахь арга нь оношилгоо үнэлгээний орчин үеийн хандлагад тохирсон “өөрийн” аргыг боловсруулахад оршино. Сэтгэц оношилгооны онол практикийн асуудал хөгжлийнхөө эхний үе шатанд байгаа манай орны хувьд эхний арга замыг сонгосноор сэтгэц оношилгооны аргачлалуудын практик хэрэглээний олон улсын туршлагаас суралцах, цаашид өөрийн орны уламжлал, нийгэм-соёлын нөхцөлд тохирсон “өөрийн” аргачлалуудыг бүтээх суурь тавигдана.

Бид ОХУ-ын Буриадын Багшийн Их Сургууль, Хятадын ӨМӨЗО-ны Хөх Хотын Багшийн Их Сургуультай хамтран хэрэгжүүлэхээр тохирсон “Монгол үндэстэн хүүхдийн сэтгэц- физиологи, нийгэм соёлын онцлог” сэдэвт төслийн хүрээнд 11-18 настай хүүхдүүдийн оюун ухааны хөгжлийн түвшинг судалсан. Сургуулийн ахлах ба бага, өсвөр насны сурагчдын оюун ухааныг үнэлэхэд Америкийн сэтгэл зүйч Д.Векслерийн боловсруулсан WISC (Wechsler Intelligence Scale for Children), WAIS (Wechsler Adult Intelligence Scale, 16-64 нас) аргачлалыг сонгож хэрэглэлээ. Д.Векслер эдгээр аргачлалуудыг боловсруулахдаа *Оюун ухаан гэдэг нь өөрийгөө зорилго чиглэлтэй авч явах, оновчтой сэтгэх, хүрээлж буй орчинтой амжилттай харилцан үйлчлэлцэх болон орчиндоо дасан зохицох хувь хүний цогц чадвар* гэсэн ойлголтод тулгуурлажээ.

Судалгааг 2009-2010 оны хооронд хийсэн бөгөөд нийт 640 суралцагчийг хамруулав. (Хүснэгт1, 2)

Хүснэгт 1

Судалгаанд хамрагдсан сурагчдын тоо (11-15 нас)

	11 нас		12 нас		13нас		14 нас		15 нас		Нийт
	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	эр	эм	
УБ хот	8	8	8	8	8	8	8	8	8	8	80
Төв	8	8	8	8	8	8	8	8	8	8	80
Сэлэнгэ	8	8	8	8	8	8	8	8	8	8	80
Дорнод	8	8	8	8	8	8	8	8	8	8	80
Ховд	8	8	8	8	8	8	8	8	8	8	80
Нийт	40	40	40	40	40	40	40	40	40	40	400

Хүснэгт 2

Судалгаанд хамрагдсан сурагчдын тоо (17-18 нас)

	16 нас		17 нас		18 нас		Нийт
	эр	эм	эр	эм	эр	эм	
УБ хот	8	8	8	8	8	8	48
Төв	8	8	8	8	8	8	48
Сэлэнгэ	8	8	8	8	8	8	48
Дорнод	8	8	8	8	8	8	48
Ховд	8	8	8	8	8	8	48
Нийт	40	40	40	40	40	40	240

Оюун ухааны хөгжлийн түвшин

Оюун ухааны хөгжлийг тусгай тестээр хэмжин коэффициентоор тодорхойлох судалгаа 20 дугаар зууны эхэн үеэс өнөөг хүртэл үргэлжлэн хийгдсээр байна. Үүнд Стенфорд-Бинегийн тестийн тав дахь хэвлэлд (SB5, 2003) оюун ухааны хөгжлийг 9 түвшинд, Вүүдкокк Жонсоны танин мэдэхүйн чадамжийн тестээр (Woodcock-Johnson Test of Cognitive Abilities –WJ III, 2007) танин мэдэхүйн чадамжийн түвшинг 7, Кауфманы багш сорилоор 7, Ялгаварт чадамжийн шкалаар 7 (DAS), түвшинд тус тус ангилан үзсэн байдаг. Оюун ухааныг тал бүрээс нь судалж түвшинчлэн үзсэн ангиллуудаас 30 орчим нь нэлээд түгээмэл байгаагаас бид өнөөг

хүртэл ач холбогдлоо алдаагүй хэрэглэгдсээр байгаа Давид Векслерийн боловсруулсан дээрх хоёр сорилын судалгаанд тулгуурлан сургуулийн ахлах болон бага, дунд насны сурагчдаас авсан судалгааг шкал онооны үзүүлэлтүүдээр нь дараах 7 түвшинд авч үзлээ. Д. Векслер хүүхдийн болон насанд хүрэгчдийн оюун ухааны хөгжлийн түвшинг “маш өндөр”(130-аас дээш), “өндөр”(120-129), “дундажаас дээгүүр”(110-119), “дундаж”(90-109), “дундажаас доогуур”(80-89), “хязгаарлагдмал”(70-79), “маш доогуур”(69-өөс доош) гэж тус тус ангилсныг түүний тестээр авсан судалгааны үр дүнг жиших жишиг болгон хэрэглэж байгаа билээ.

Хүснэгт 3

11-15 настай сурагчдын оюун ухааны түвшингийн зүүлэлтүүдийн эзлэх хувь (n=400)

Нас	Хүйс	Оюун ухааны хөгжлийн түвшин						
		69 -өөс доош	70-79	80-89	90-109	110-119	120-129	130-аас дээш
11 нас	Эм	0	0	7,5	37,5	20	20	15
	Эр	0	5	0	17,5	30	22,5	25
	Нийт	0	2,5	3,75	27,5	25	21,25	20
12 нас	Эм	0	2,5	2,5	22,5	17,5	27,5	27,5
	Эр	0	2,5	2,5	27,5	17,5	17,5	32,5
	Нийт	0	2,5	2,5	25	17,5	22,5	30
13 нас	Эм	0	2,5	10	40	20	17,5	10
	Эр	0	2,5	0	40	20	27,5	10
	Нийт	0	2,5	5	40	20	21,25	11,25
14 нас	Эм	2,5	5	5	32,5	30	15	10
	Эр	0	0	10	37,5	17,5	22,5	12,5
	Нийт	1,25	2,5	7,5	35	23,75	18,75	11,25
15 нас	Эм	2,5	0	0	37,5	27,5	17,5	15
	Эр	0	2,5	7,5	50	15	17,5	7,5
	Нийт	1,25	1,25	3,75	43,75	21,25	17,5	11,25
Ерөнхий	Эм	1	2	5	34	23	19,5	15,5
	Эр	0	2,5	4	34,5	20	21,5	17,5
	Нийт	0,5	2,25	4,5	34,25	21,5	20,25	16,75


Бидний судалгаанд хамрагдсан 11-15 насны сурагчдын 16,75% нь оюун ухааны хөгжлийн “маш өндөр”, 20,25%, “өндөр”, 21,5 “дундажаас дээгүүр” 34,25 % нь “дундаж” түвшинд харьяалагдаж байгаа бөгөөд нийт судлуулагчдын 95,7% нь оюун ухааны хөгжлийн дундаж ба түүнээс дээш түвшинд багтаж байна гэсэн үг. Оюун ухааны хөгжлийн дундажаас доогуур түвшинд 4,5% нь, хязгаарлагдмал түвшинд 2,25% нь, маш доогуур түвшинд 0,5% нь харьяалагдаж байна. (Хүснэгт-3, График-1)

Диаграмм 1

Оюун ухааны түвшингийн ерөнхий үзүүлэлт



Судалгааны явцад илэрсэн дээрх үзүүлэлтүүдийг Д. Векслерийн тодорхойлсон оюун ухааны хөгжлийн түвшингийн жишиг мурийтай харьцуулж үзэхэд монгол сурагчдын оюун ухааны хөгжлийн түвшин харьцангуй өндөр байна. (График -2)



Хүснэгт 4

Судлуулагчдын оюун ухааны хөгжлийн түвшинг стандарт жишигтэй харьцуулсан байдал

Хүйс	Оюун ухааны хөгжлийн төвшин						
	69 хүртэлх	70-79	80-89	90-109	110-119	120-129	130-с дээш
Эмэгтэй	1	2	5	34	23	19,5	15,5
Эрэгтэй	0	2,5	4	34,5	20	21,5	17,5
Ерөнхий	0,5	2,25	4,5	34,25	21,5	20,25	16,75
Стандарт жишиг	2,2	6,7	16,1	50	16,1	6,7	2,2

Сургуулийн бага ба өсвөр насныхны оюун ухааны хөгжлийн түвшинг насны байдлаар нь авч үзвэл оюун ухааны хөгжлийн өндөр ба маш өндөр түвшин гэсэн зэрэглэлд 12, 11 насны

судлуулагчдын эзлэх хувь бусад наснаас илүү байгаа бол 13-15 насны судлуулагчдын 60 орчим хувь нь дундаж ба дундажаас дээгүүр гэсэн ангилалд багтаж байна. (Хүснэгт 5, Диаграмм 1)

Хүснэгт 5

Оюун ухааны ерөнхий түвшин (11-15 нас)

	69 хүртэлх	70-79	80-89	90-109	110-119	120-129	130-аас дээш
11 нас	0	2,5	3,75	27,5	25	21,25	20
12 нас	0	2,5	2,5	25	17,5	22,5	30
13 нас	0	2,5	5	40	20	21,25	11,25
14 нас	1,25	2,5	7,5	35	23,75	18,75	11,25
15 нас	1,25	1,25	3,75	43,75	21,25	17,5	11,25
Ерөнхий	0,5	2,25	4,5	34,25	21,5	20,25	16,75

Хүснэгт 6


Ахлах ангийн сурагчдын оюун ухааны хөгжлийн түвшин (n=240)

	Хүйс	Оюун ухааны хөгжлийн төвшин						
		69 хүртэлх	70-79	80-89	90-109	110-119	120-129	130-с дээш
16 нас	Эм			2.5	35	25	32.5	5
	Эр			12.5	37.6	35	15	
	Нийт			7.5	36.25	30	23.75	2.5
17 нас	Эм				27.5	42.5	25	5
	Эр				27.5	45	25	2.5
	Нийт				27.5	43.75	25	3.75
18 нас	Эм			5	57.5	22.5	15	
	Эр			5	37.5	37.5	20	
	Нийт			5	47.5	30	17.5	
Ерөнхий	Эм			2.5	40	30	24.16	3.3
	Эр			5.83	34.2	39.16	20	0.83
	Нийт			4.16	37.1	34.6	22.08	2.06

Судалгаанд хамрагдсан 16-18 насны сурагчдын оюун ухааны хөгжлийн үзүүлэлтүүдийг авч үзэхэд (Хүснэгт 6, график 3) дундаж түвшинд 37.1%, дунджаас дээгүүр төвшинд 34.6%, өндөр түвшинд 22,08%, маш өндөр түвшинд 2.06 % нь тус тус харьяалагдаж байна. Оюун ухааны хөгжлийн хязгаарлагдмал болон маш доогуур түвшингийн илрэл ахлах ангийн энэхүү судалгааны түүврийн хүрээнд илрээгүй.

Диаграмм 3

Оюун ухааны хөгжлийн түвшин (16-18 нас)



Хүснэгт 7

Ахлах ангийн сурагчдын оюун ухааны түвшингийн дундаж ба стандарт хазайлт

Нас	Судлуулагчдын тоо	IQ үгэн		IQ үгэн бус		IQ ер	
		M	SD	M	SD	M	SD

Хүснэгт 8

Судлуулагчдын оюун ухааны хөгжлийн түвшинг хүйсээр харьцуулсан байдал (11-15 нас)

	69 хүртэлх	70-79	80-89	90-109	110-119	120-129	130-с дээш
Эмэгтэй	1	2	5	34	23	19,5	15,5
Эрэгтэй	0	2,5	4	34,5	20	21,5	17,5
Ерөнхий	0,5	2,25	4,5	34,25	21,5	20,25	16,75
Стандарт жишиг	2,2	6,7	16,1	50	16,1	6,7	2,2

16 нас	80	114.5	14.04	105.2	11.3	111.2	11.8
17 нас	80	118.5	9.86	108	9.4	114.7	8.5
18 нас	80	111.2	11.74	104	12.1	108.7	9.9

Судалгааны дүнгээс харахад ахлах ангийн сурагчдын оюун ухааны хөгжлийн түвшин ерөнхийдөө дундажаас дээгүүр (M=111, M=114, M=108,7) үгэн оюун ухааны түвшин (16 нас: M=114, 17 нас: M=118,5, 18 нас: M=111) үгэн бус оюун ухаанаас (M=105,2, M=108, M=104) харьцангуй өндөр байна. Эрэгтэй, эмэгтэй сурагчдын оюун ухааны түвшний хоорондын ялгаа ялимгүй бага.

Судлуулагчдын оюун ухааны хөгжлийн түвшинг насны байдлаар нь авч үзвэл 11, 12 настай хүүхдүүдийн оюун ухааны хөгжлийн түвшин өндөр ба маш өндөр зэрэглэлд илүү жин эзэлж байсан бол сургуулийн ахлах насанд дундаж ба дунджаас дээш гэсэн зэрэглэлд судлуулагчдын 71,6% нь, харин өндөр түвшинд 22,08% нь багтаж байна. Сурагчдын нас ахих тусам оюун ухааны хөгжлийн маш өндөр ба маш доогуур түвшинд харьяалагдах ялгарал аажмаар багасч, дундаж ба дунджаас дээш түвшин орчимд жигд тархалт илрэх хандлага ажиглагдлаа.



Бидний судалсан түүврийн хэмжээнд судлуулагчдын оюун ухааны хөгжлийн ерөнхий түвшинд хүйсийн ялгаа илрээгүй, харин даалгаврын бүтцийн шинжилгээнд зарим талын ялгаа байх магадлалтайг энэхүү илтгэлийн дараагийн хэсгээс харах боломжтой.

Хоёр. Даалгаврын гүйцэтгэлийн анализ:


Хүснэгт 9

Тестийн даалгавруудын шкал үнэлгээний дундаж (WISC: 11-15 нас)

	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
эрэгтэй	11,9	15,0	11,5	15,2	15,1	12,4	15,4	10,6	12,6	8,3	8,8	9,1
эмэгтэй	11,3	14,6	10,9	14,9	14,4	11,9	14,3	9,1	11,4	7,5	9,7	8,7
нийт	11,6	14,8	11,2	15,1	14,7	12,1	14,9	9,8	12,0	7,9	9,2	8,9


Диаграмм 6

Тестийн даалгаврын шкал үнэлгээний дундаж (WISC: 11-15 нас)



Диаграмм 7

Тестийн даалгаврын шкал үнэлгээ (WAIS:16-18 нас)



Хүснэгт 10

Тестийн даалгаврын шкал үнэлгээ (WAIS: 16-18 нас)

Нас	Дэд сорилуудын дугаар										
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
16 нас	11	13.3	10.5	12.1	8.9	13.6	8.7	12.3	11.8	10.4	9.5
17 нас	11	12.4	11.0	12.4	9.2	12.0	8.8	12.2	12.8	11.7	10.0
18 нас	10.8	13.7	10.4	12.1	8.5	13.1	8.3	12.2	12.0	10.4	9.8
Дундаж	10.9	13.1	10.7	12.2	8.8	12.9	8.6	12.2	12.2	10.6	9.8

Д.Векслерийн тестийн үгэн бус дэд сорилууд нь оюун ухааны хөгжлийн дотоод бүрдэл ба хувийн онцлогийг тодорхойлоход нэн тохиромжтой. Бидний судалгаанаас үзэхэд нийт дэд сорилуудын гүйцэтгэлийн шкалчилсан үнэлгээ нь хүүхдийн хувилбараар авсан судалгаанд 7,9–өөс 15,08-ын хооронд насанд хүрэгчдийн хувилбараар авсан судалгаанд 8,62–оос 13,14 шкал онооны хооронд тус тус хэлбэлзэж байгаа нь сайн үзүүлэлт юм. Учир нь шкал үнэлгээний дундаж 10 байх ёстой.

Хүүхдийн хувилбараар авсан тестийн даалгаврын гүйцэтгэлийн 75% нь дунджаас дээш шкал оноотой,үлдсэн 25% нь буюу 3 дэд сорилын шкал үнэлгээ дунджаас доогуур, насанд хүрэгчдийн хувилбараар авсан судалгааны даалгаврын гүйцэтгэлийн 72,7% нь дундаж шкал үнэлгээнээс дээгүүр байна.(Хүснэгт 9, 10, график 6,7)

Судалгаанд хамрагдсан Монгол хүүхдүүдийн оюун ухааны даалгаврын гүйцэтгэлийн өндөр шкал үнэлгээ:

Дөрөвдүгээр дэд сорил (“адил төсөөг олох”), долдугаар дэд сорил (“Дутуу зүйлийг гүйцээх”), “Хоёрдугаар дэд сорил (“Ойлгоц”), Тавдугаар дэд сорил (“Толь бичиг”) зэрэг дэд сорилуудын даалгаврын гүйцэтгэлийн шкал үнэлгээ дунджаас өндөр байна. Өндөр шкал үнэлгээ бүхий судлуулагчдын онцлогийг товч дурдъя:

1. “Адил төсөө” хэмээх дэд сорилын гүйцэтгэлээс үзэхэд монгол хүүхдүүдийн мэдээллийг хийсвэрлэх, ангилан бүлэглэх, харьцуулах, эрэмбэлэх чадварт суурилсан ухагдахуунт сэтгэлгээ сайн хөгжсөн байна.
2. “Дутуу зүйлийг гүйцээх” дэд сорилын гүйцэтгэл өндөр байгаа нь судлуулагчдын юмыг шууд хүртэх үеийн (перцептив) анхаарал, ажигч чанар, төвлөрөх чадвар сайн байгаагийн илрэл
3. Бие даах чадвар, нийгмийн эргэцүүллийн түвшинг илтгэгч “Ойлгоц”, дэд сорилын гүйцэтгэл 11-18 настай Монгол хүүхдүүдийн хувьд дунджаас дээгүүр гарчээ. (13,14 шкал үнэлгээтэй)
4. “Толь бичиг” дэд сорилын гүйцэтгэлээс судлуулагчийн боловсрол, соёл, үгийн нөөц, үгийн утгыг бүрэн дүүрэн, оновчтой илэрхийлэх мэдрэмж, хэм хэмжээ өндөр түвшинд байгаа нь харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан монгол хүүхдүүдийн оюун ухааны даалгаврын гүйцэтгэлийн дундаж шкал үнэлгээ:

Зургадугаар дэд сорил (“Тоон эгнээг давтах”), есдүгээр дэд сорил (“Косын шоо”), нэгдүгээрдэдсорил (“Ердийнмэдлэг”), гуравдугаар дэд сорил (“Арифметик”), наймдугаар дэд сорил, (“Зургийн дараалал”) зэрэг дэд сорилуудын даалгаврын гүйцэтгэлийн шкал үнэлгээ дундаж ба дунджаас ялимгүй дээгүүр байна. Шкалын дундаж үнэлгээ бүхий судлуулагчдын онцлог:

5. “Тоон эгнээг давтах” дэд сорилын гүйцэтгэлээс үзэхэд судалгаанд хамрагдсан Монгол хүүхдүүдийн ой, анхаарал зэрэг чадварууд дунджаас ялимгүй өндөр (12,5 шкал үнэлгээтэй) байна.
6. “Косын шоо” дэд сорилын гүйцэтгэлээс харахад судалгаанд хамрагдсан сурагчдын бүхэл бүтэн зүйлийг түүний бүрэлдэхүүн хэсгүүдээр нь дамжуулан анализ хийх чадвар ба орон зайн дүрслэл хийх чадвар дунджаас ялимгүй дээгүүр (11,99 шкал үнэлгээтэй) байна.
7. “Ердийн мэдлэг” дэд сорил: Судалгаанд хамрагдсан 11-15 настай Монгол хүүхдүүдийн холбогдох үнэлгээ нь дунджаас ялимгүй дээгүүр (11,57) байна.

8. “Арифметикийн” дэд сорил нь зориудын анхаарал, юмны учрыг ухааж ойлгох, тоон үйлдлүүдийг оновчтой хийх чадварыг тодорхойлно. Судлуулагчдын энэ чадвар мөн дунджаас ялимгүй дээгүүр (11, 2) шкал үнэлгээтэй байна.

9. “Зургийн дараалал” дэд сорил нь саланга зүйлүүдийг нэгтгэх, перцептив анхаарал ба юмсыг “Бүртгэн харах” чадвар, үйл явцыг ойлгох, урьдчилан төсөөлөх чадварыг тодорхойлно. Судлуулагчдын эдгээр чадварын шкал үнэлгээ дундаж (9,8) түвшинд байна.

Судалгаанд хамрагдсан Монгол хүүхдүүдийн оюун ухааны даалгаврын гүйцэтгэлийн дунджаас доогуур шкал үнэлгээ: Арванхоёрдугаар туслах дэд сорил (“Лабиринтууд”), арваннэгдүгээр дэд сорил (“Шифрлэх”), аравдугаар дэд сорил (“Дүрс эвлүүлэх”) дунджаас доогуур байна. Эдгээр даалгавруудыг дунджаас доогуур шкал үнэлгээтэй гүйцэтгэсэн сурагчдын онцлог:

10. “Шифрлэх” дэд сорилоор анхаарлын шинжүүд, хүртэхүй хараа хөдөлгөөний зохилдлогоо, шинэ дадал төлөвших хурд дундаж түвшинд хараахан хүрэхгүй байна (9,25 шкал үнэлгээ)

11. “Лабиринтууд” дэд сорил нь хүүхдийн аналитик чадварыг урьдчилан илэрхийлнэ. Хүртэхүйн даалгавруудыг дараалуулан гүйцэтгэх чадвар, зааврыг ойдоо хадгалан баримтлах, анхаарлын тогтворжилт ба зориудын шинж чанар, үйлдлийн ойн үр дүнт байдал зэрэг нь дунджаас доогуур (8,9 шкал үнэлгээтэй) байна.

12. “Дүрс эвлүүлэх” дэд сорил салангид зүйлүүдийг бүхэлтэй нь харьцуулан дүрсийг бодитойгоор эвлүүлэхэд эвристик сэтгэлгээний элементүүд шаардагддаг байна. Энэ дэд сорилын гүйцэтгэлийн шкал үнэлгээ бусад дэд сорилуудаас хамгийн доогуур буюу (7,9) шкалын дунджаас 2,1 оноогоор доогуур байна.

Сургуулийн ахлах насны судлуулагчдын даалгаврын гүйцэтгэлийг ерөнхийд нь авч үзвэл (хүснэгт 10, график 7) дараах дүр зураг харагдаж байна:

1. Сургуулийн ахлах насны сурагчдын тестийн даалгаврын гүйцэтгэлд анализ хийж үзэхэд нийт 11 дэд сорилын 8 нь шкалын дундаж ба дунджаас дээгүүр үнэлгээтэй байна: нэгдүгээр дэд сорил -ойлгоц (13,14 шкал үнэлгээтэй), зургадугаар дэд сорил -толь бичиг (12,92 шкал үнэлгээтэй), наймдугаар дэд сорил-дутууг хасах (12,25 шкал үнэлгээтэй), есдүгээр дэд сорил- косын

шоо (12, 24 шкал үнэлгээтэй), нэгдүгээр дэд сорил-ердийн мэдлэг (10,93 шкал үнэлгээтэй).

2. 11 дүгээр дэд сорил (дүрс эвлүүлэх) 9,76 буюу шкалын дундаж үнэлгээтэй.
3. Тавдугаар дэд сорил (тоог давтах: 8,84) ба долоодугаар дэд сорилын (шифр:8,62) шкал үнэлгээ дунджаас ялимгүй доогуур төвшинд байна.

Анхаарлын шинжүүд хүртэхүй, хараа хөдөлгөөний зохицолдогоо, шинэ дадал төлөвших хурд зэргийг тодорхойлдог дэд сорил болох “Шифр” ба “Дүрс эвлүүлэх” (салангид зүйлүүдийг бүхэлтэй нь харьцуулан дүрсийг бодитойгоор эвлүүлэхэд чиглэсэн эвристик сэтгэлгээний элементүүд шаардагддаг) дэд сорилын шкал үнэлгээ 11-18 насны нийт судлуулагчдын түүвэрт бусад дэд сорилуудын шкал үнэлгээнээс бага зэрэг доогуур байгааг анхаарах хэрэгтэй. Нийт судлуулагчдын үгэн IQ-г түвшин үгэн бус IQ-гээс дээгүүр байгаа бөгөөд үүнд хүйсээс хамаарах хамаарал илэрч байгаа эсэхийг авч үзэхэд (График 8, Хүснэгт.11) эмэгтэй сурагчдын үгэн ба үгэн бус IQ нь дунд ба дундаас дээгүүр хамааралтай, хөвгүүдийнх 11 насандаа сул, бусад насандаа дунд ба дунджаас дээгүүр хамааралтай боловч охидынхоос ялимгүй доогуур байна. Судлуулагчдын нас ахих тусам үгэн ба үгэн бус IQ-ийн хамаарал өсөх хандлагатай байгаа боловч боловч 15 насанд эргээд буурч байгаагийн шалтгааныг нягтлах шаардлагатай байна.

Гурав. Судалгааны практик ач холбогдолын тухай

Бид Монгол хүүхдийн оюун ухааны хөгжлийг тодорхойлох энэхүү судалгаандаа дэлхийн сэтгэл судлалын шинжлэх ухаанд хүлээн зөвшөөрөгдсөн суурь тестийг эх хэлнээ орчуулан хэрэглэж, судалгааны тестийн сан бүрдүүлэх анхны алхмыг хийлцсэн, уг тестүүдийг ашиглан судалгааны түүврийг өргөтгөх боломжийг нээлттэй үлдээж, залуу судлаачдыг шавилуулан сургах, судлаачдын хамтын ажиллагааны туршлага хуримтлуулсан билээ. Энэ мэт олон практик ач холбогдлыг дурдаж болох хэдий ч энэхүү илтгэлийн хүрээнд суурь судалгааны үр дүнг судлуулсан хүн нэг бүрт зөвлөн туслахад хэрхэн ашиглах вэ? гэсэн асуултад хариулах нь эн тэргүүний практик ач холбогдолтой гэж үзлээ. Уг асуултын хариуг дараах хоёр чиглэлээр тодорхойлж байна.

Практик ач холбогдол 1

Бид оюун ухааны хөгжлийн энэхүү судалгаагаараа 11-18 насны Монгол сурагчдын

оюун ухааны хөгжлийн дундаж түвшинг анх удаа 640 судлуулагчдын түүвэрт тулгуурлан тогтоосон нь хэн нэгэн хүүхдийн оюун ухааны хөгжлийн түвшинг үе тэнгийнх нь хүүхдүүдийн дундажтай харьцуулан тодорхойлох боломжтой боллоо.

Практик ач холбогдол 2

Судлуулагч тус бүрийн оюун ухааны профилийг (зураглал) тодорхойлж, сэтгэл зүйн үнэлгээ ба зөвлөгөөг өгөх жишгийг харуулсан. Үүнийг 11-15 насны сурагчдын дундаж IQ-ийн дундаж шкал онооны үзүүлэлтээр жишээ болгон авч үзлээ. (График 9, хүснэгт 12)

Судлуулагчдын гүйцэтгэсэн дэд сорилуудын дундаж шкал үнэлгээ ба дундаж IQ үзүүлэлт (11-15 нас)



Сэтгэл судлаачийн дүгнэлт

Монголын 11-15 настай сурагчдын үгэн IQ=120,4, үгэн бус IQ=103, ерөнхий IQ=113,7 байна. Үзэгдэл юмсын шинжийг утга зүйн талаас нь ерөнхийлөн дүгнэх, утга зүйн ерөнхийлөл хийх, перцептив анхаарал, ажигч чанар, амьдралын туршлага дээрээ тулгуурлан оюун дүгнэлт гаргах нийгмийн эрэгцүүлэл хийх чадвар сайн хөгжсөн, боловсрол, соёлын сэтгэлгээ сайтай, төрөлх хэлнийхээ үгийг чөлөөтэй хэрэглэх чадамжтай. Тэдний эвристик сэтгэлгээ, өгөгдсөн зааврын дагуу бодит даалгавруудыг дарааллын дагуу гүйцэтгэх чадвар, шинэ дадал эзэмших хурдыг илүү сайжруулахад анхаарах шаардлагатай.

Сэтгэл судлаач-----гарын үсэг

Судалгааны хязгаарлагдмал тал

Монгол хүүхдийн оюун ухааны хөгжлийг судлах энэхүү судалгаа нь оюун ухааны тестийг иж бүрнээр нь орчуулан хэрэглэсэн анхны судалгаа байсан учраас судалгааны арга зүйн

бэлтгэлд ихээхэн хөдөлмөр, цаг зарцуулсан, дахин тестчлэлээр тестийн баталгаат чанарыг тодорхойлж амжаагүй, Равены өсөх матрицын аргаар авсан судалгаа болон бие хүний онцлогийг судлах бусад тестүүдийн үр дүнтэй оюун ухааны тестийн үр дүнг харьцуулж жишиж үзээгүй Буриад ба Өвөрмонгол хүүхдүүдийн судалгааны нэгдсэн дүнтэй харьцуулж амжаагүй зэрэг хязгаарлагдмал зарим талтай. Мөн судалгаанд тухайн насны бүлэг тус бүрээс 80 (эрэгтэй 40, эмэгтэй 40) сурагчийг сонгон дээрх 5 аймаг, Улаанбаатар хотоос 640 сурагчийг төлөөлөл болгон авсан нь Монголын сургуулийн насны нийт 512.213 хүүхдийн бүрэн төлөөлөл болж чадахгүй.

Судалгааны дүгнэлт ба хэтийн төлөв

1. Бидний судалгаанд хамрагдсан түүврийн хэмжээнд Монголын ЕБС-ын оюун ухааны хөгжлийн түвшин дундаж ба түүнээс дээгүүр төвшинд байна. Үүнд 11 настай сурагчдын дундаж IQ=119,1, 12 настай сурагчдын дундаж IQ=118, 13 настай сурагчдын дундаж IQ=110, 14 настай сурагчдын дундаж IQ=109,9 15 настай сурагчдын дундаж IQ=110,6, 16 настай сурагчдын дундаж IQ=114,5, 17 настай сурагчдын дундаж IQ=118,5, 18 настай сурагчдын IQ=111.2 байна.
2. Даалгаврын гүйцэтгэлийн шкал үнэлгээнээс үзэхэд үгэн IQ нь үгэн бусаасаа дээгүүр, Сэтгэхүйн үйлүүдэд суурилсан ухагдахуунт сэтгэлгээ, перцептив анхаарал, ажигч чанар, бие даан сэтгэх, нийгмийн эргэцүүлэх чадвар, үгийн утгыг бүрэн оновчтой илэрхийлэх мэдрэмж сайн хөгжсөн байна. Харин шинэ дадал төлөвших хурд, даалгавруудыг өгөгдсөн зааврын дагуу дараалуулан гүйцэтгэх чадвар ба эвристик сэтгэлгээний хөгжлийг сайжруулахад анхаарах хэрэгтэй байна.
3. Судалгааны үр шимийг судлуулагчдад эргүүлэн хүртээх олон арга зам байгаагийн нэг нь бидний боловсруулсан жишиг профиль маягаар сурагч нэг бүрийн оюун ухааны хөгжлийн тухайн үеийн байдал болон онцлогийг мэргэжлийн сэтгэл судлаачдын туслалцаатайгаар оношлон зөвлөгөө өгөх боломжтой.
4. Энэхүү судалгааны найдварт чанарыг хангах үүднээс судалгааны түүврийг Монгол хүүхдийн төлөөлөл хангах хэмжээнд өргөтгөх, Монгол хүүхдийн оюун ухаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлэх, бусад орнуудын ялангуяа ОХУ-ын БИС, БНХАУ-ӨМӨЗО-ны БИС-ийн хийсэн судлаачдын судалгааны үр дүнтэй холбох, оюун ухаан танин мэдэхүй, бие хүний онцлогийг

тодорхойлох бусад тестүүдтэй хослуулан хэрэглэх замаар судлуулагчийн хөгжлийн тухайн үеийн дур зураг болон Монгол хүүхдийн хөгжлийн онцлогийг иж бүрнээр нь тодорхойлоход анхаарах хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

John, J., Zechmeister B. (1997). *Research Methods in Psychology*. Boston.

Батдэлгэр, Ж., Дашхүү, Д., Мягмар, О., Цэндсүрэн, Т. (2006). *Хүүхдийн оюун ухааны хөгжлийн ерөнхий төвшинг тодорхойлох сорил*. Улаанбаатар

Бурлачук, Л.Ф. (1997). *Словарь-справочник по психодиагностике*. Санкт-Петербург. Питер.

Мягмар, О. (2007). *Хувийн дасан зохицохуй*. Улаанбаатар

Саруул, Д. (2009). Оюун ухааны хөгжлийн төвшинг тодорхойлсон дүнгээс (Ховд аймгийн өсвөр ба ахлах насныхны жишээн дээр). *Сэтгэл судлалын ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл*. Улаанбаатар

Туяа, Б. (2011). *Сэтгэц оношлогооны тайлбар толь*. Улаанбаатар

Филимоненко, Ю.И., Тимофеев, В.И., Векслера, Д. (2002). *Диагностика структуры интеллекта (Детский вариант) Методическое руководство*. Г.П."ИМАТОН".

Филимоненко, Ю.И., Тимофеев, В.И., Векслера, Д. (2002). *Диагностика структуры интеллекта (Взрослый вариант) Методическое руководство*. Г.П."ИМАТОН". Орчуулсан Туяа.

<http://www.twirpx.com/file/199949/>

<http://www.ebooks4university.com/fileinfo1239.html>

<http://www.bestreferat.ru/referat-149712.html>

<http://www.psilib.org.ua/books/holli01/index.htm>

<http://www.psibib.ru/spec/teokonc/fakteol.php>

"Монгол туургатан хүүхэд" эмхэтгэл. 2015